E 100<sup>0</sup> 34' 56,4" elev-1247 м
- OR-170.** Том том чулуун дараастай дугуй булш. Хэмжээ: 4,7 м.  
Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 19,6"  
E 100<sup>0</sup> 34' 57,4" elev-1247 м
- OR-171.** Дөрвөлжин хүрээнийх нь зүүн тал л үлдсэн байх бөгөөд зүүн талдаа 2 дагуул бүхий. Голын байгууламж нь том том чулуун дараастай. Хэмжээ: 8,6 м.  
Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 18,0"  
E 100<sup>0</sup> 35' 00,3" elev-1247 м
- OR-172.** Том том чулуун дараастай дугуй булш. Хэмжээ: 7,3 м.  
Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 18,2"  
E 100<sup>0</sup> 34' 53,7" elev-1249 м
- OR-173.** Жижгэвтэр чулуун дараас бүхий дугуй хэлбэртэй байгууламж. Хэмжээ: 5,7 м.  
Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 17,9"  
E 100<sup>0</sup> 34' 50,7" elev-1250 м
- OR-174.** Том том чулуун дараас бүхий дугуй хэлбарийн байгууламж. Хэмжээ: 9,8 м.  
Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 14,7"  
E 100<sup>0</sup> 34' 57,1" elev-1252 м
- OR-175.** Дөрвөлжин хүрээний ором үлдэж, хүрээний 4 өнцөгт нь том том чулуу босгожээ. Голын байгууламж нь том том чулуун дараастай. Хүрээний хэмжээ: 11,7 х 9,2 м. Голын байгууламжийн хэмжээ: 7,9 м.  
Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 13,3"  
E 100<sup>0</sup> 34' 54,8" elev-1257 м
- OR-176.** Дугуй хүрээнийх нь хойд тал нь үлджээ. Голын байгууламж нь том том чулуун дараастай. Хэмжээ: 12,4 м.  
Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 07,5"  
E 100<sup>0</sup> 34' 48,2" elev-1262 м
- OR-177.** Дөрвөлжин хүрээтэй, хүрээнийхээ 4 өнцөгт жижиг байгууламжтай. Хүрээний баруун тал жалга руу нурж, урд тал нь мэдэгдэхээ больжээ. Хүрээний гадна хойд болон урд талдаа тус бүр 2 дагуул, хүрээний дотор хойд талдаа 1 дагуул бүхий.

Голын байгууламж нь том том чулуун дараастай. Голын байгууламжийн хэмжээ: 12 м. Хүрээний хэмжээ: 17 x 15,5 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 16,4"  
E 100<sup>0</sup> 34' 55,7" elev-1259 м

**OR-178.** Дугуй хүрээтэй, голын байгууламж нь том том чулуун дараастай. Голын байгууламжийн хэмжээ: 9,9 м. Хүрээний хэмжээ: 12,3 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 05,9"  
E 100<sup>0</sup> 34' 55,5" elev-1266 м.

\* Дээрх байгууламжийн өмнө талд голдоо чулуугүй дугуй булш оршино. Хэмжээ: 4,9 м.

**OR-179.** Гол нь хотгор том том чулуун дараас бүхий дугуй хэлбэртэй байгууламж. Хэмжээ: 11,2 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 04,5"  
E 100<sup>0</sup> 34' 54,1" elev-1263 м

**OR-180.** Дөрвөлжин хүрээний баруун тал нь үлджээ. Голын байгууламж нь том том чулуун дараастай. Хэмжээ: 12,3 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 02,1"  
E 100<sup>0</sup> 34' 54,1" elev-1262 м

**OR-181.** Дөрвөлжин хүрээний хойд тал нь үлджээ. Голын байгууламж нь том том чулуун дараас бүхий. Хэмжээ: 9,3 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 01,1"  
E 100<sup>0</sup> 34' 54,0" elev-1271 м

**OR-182.** Хэлбэр нь мэдэгдэхээ больсон, том том чулуун дараас бүхий байгууламж.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 01' 55,6"  
E 100<sup>0</sup> 34' 55,8" elev-1282 м

**OR-183.** Дөрвөлжин хүрээтэй, хүрээний 4 өнцөгт нь том том чулуу босгожээ. Хүрээний гадна зүүн талд нь 2 эгнээ 9 дагаалтай. Голын байгууламж нь том том чулуун дараас бүхий. Голын байгууламжийн хэмжээ: 11 м. Хүрээний хэмжээ: 13,5 x 10,3 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 01' 45,9"  
E 100<sup>0</sup> 34' 52,6" elev-1300 м

**OR-184.** Дөрвөлжин хүрээтэй, хүрээнийхээ 4 өнцөгт жижиг байгууламжтай. Хүрээний гадна зүүн талдаа 2 дагуул бүхий. Голын байгууламж нь голдоо хотгор, том том чулуун дараастай. Голын байгууламжийн хэмжээ: 10 м. Хүрээний хэмжээ: 10,3 x 9,6 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 01' 44,5"  
E 100<sup>0</sup> 34' 52,6" elev-1305 м

**OR-185.** Голдоо хотгор, том том чулуун дараас бүхий дугуй хэлбэртэй байгууламж. Хэмжээ: 13,5 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 01' 41,3"  
E 100<sup>0</sup> 34' 53,1" elev-1308 м

**OR-186.** Дөрвөлжин хүрээтэй, хүрээний гадна зүүн талдаа 2 дагуул бүхий. Голын байгууламж нь том том чулуун дараастай бөгөөд хүрээтэйгээ нийлсэн байдалтай. Голын байгууламжийн хэмжээ: 8,8 м. Хүрээний хэмжээ: 11 x 7,3 м.

Байршил: GPS N 45° 01' 38,6"  
E 100° 34' 59,1" elev-1313 м

**OR-187.** Голдоо хотгор, том том чулуун дараастай дугуй булш. Хэмжээ: 5,9 м.

Байршил: GPS N 45° 01' 30,8"  
E 100° 34' 56,5" elev-1320 м

**OR-188.** Дугуй хүрээтэй, хүрээний гадна хойд талдаа 2 дагуул бүхий. Голын байгууламж нь том том чулуун дараастай. Голын байгууламжийн хэмжээ: 10,45 м. Хүрээний хэмжээ: 13,1 м.

Байршил: GPS N 45° 01' 20,7"  
E 100° 34' 55,1" elev-1343 м

**OR-189.** Дугуй хүрээтэй, хүрээний гадна зүүн талдаа 2 дагуул бүхий. Голын байгууламж нь том том чулуун дараастай. Голын байгууламжийн хэмжээ: 12 м. Хүрээний хэмжээ: 15,1 м.

Байршил: GPS N 45° 02' 17,0"  
E 100° 34' 56,8" elev-1351 м

**OR-190.** Дугуй хүрээтэй, голын байгууламж гадна хүрээтэйгээ нийлсэн, жижиг чулуун дараас бүхий. Хэмжээ: 7,9 м.

Байршил: GPS N 45° 02' 31,4"  
E 100° 35' 16,4" elev-1235 м

\* Дээрх байгууламжийн баруун хойд талд голдоо чулуугүй дугуй булш оршино. Хэмжээ: 4,5 м.

**OR-191.** Голдоо чулуугүй дугуй булш. Хэмжээ: 4,2 м.

Байршил: GPS N 45° 02' 31,1"  
E 100° 35' 17,2" elev-1232 м

**OR-192.** Дөрвөлжин хүрээтэй, хүрээний 4 өнцөгт нь том том чулуу босгожээ. Голын байгууламж нь жижгэвтэр чулуун дараастай. Голын байгууламжийн хэмжээ: 4,5 м. Хүрээний хэмжээ: 7,3 х 6,7 м.

Байршил: GPS N 45° 02' 32,2"  
E 100° 35' 20,0" elev-1232 м

**OR-193.** Дугуй хүрээтэй, голын байгууламж нь жижгэвтэр дараас бүхий. Голын байгууламжийн хэмжээ: 4,9 м. Хүрээний хэмжээ: 7,2 м.

Байршил: GPS N 45° 02' 31,8"  
E 100° 35' 20,6" elev-1230 м

**OR-194.** Дөрвөлжин хүрээтэй, голын байгууламж нь хүрээтэйгээ нийлсэн байдалтай. Хэмжээ: 4,7 х 4,4 м.

Байршил: GPS N 45° 02' 32,0"  
E 100° 35' 23,1" elev-1231 м

**OR-195.** Том том чулуугаар хүрээлсэн жижиг чулуун дараас бүхий дугуй байгууламж. Хэмжээ: 6,95 м.

Байршил: GPS N 45° 02' 34,5"  
E 100° 34' 31,3" elev-1228 м

**OR-196.** Дөрвөн талд нь том том чулуу босгосон зууван дугуй хүрээтэй. Голын байгууламж нь жижгэвтэр чулуун дараас бүхий. Голын байгууламжийн хэмжээ: 4,9 м. Хүрээний хэмжээ: 10,6 x 8,6 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 34,3"  
E 100<sup>0</sup> 35' 32,0" elev-1226 м

**OR-197.** Том том чулуугаар хүрээлсэн, голдоо жижиг дараас бүхий дугуй байгууламж. Зүүн урдаа 2 дагуултай. Хэмжээ: 4,85 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 34,9"  
E 100<sup>0</sup> 34' 59,6" elev-1227 м

**OR-198.** Том том чулуугаар хүрээлсэн, голдоо жижгэвтэр чулуун дараас бүхий дөрвөлжин хэлбэртэй булш. Хэмжээ: 4,9 x 4,1 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 34,8"  
E 100<sup>0</sup> 35' 35,5" elev-1224 м

**OR-199.** Том том чулуун дараас бүхий дугуй булш. Хэмжээ: 5,5 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 34,1"  
E 100<sup>0</sup> 35' 35,0" elev-1226 м

**OR-200.** Том том чулуугаар хүрээлсэн, голдоо жижиг чулуун дараас бүхий байгууламж. Хэмжээ: 8,5 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 34,7"  
E 100<sup>0</sup> 35' 37,3" elev-1224 м

**OR-201.** Жижгэвтэр чулуун дараастай дугуй булш. Хэмжээ: 2,5 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 27,7"  
E 100<sup>0</sup> 35' 33,4" elev-1232 м

**OR-202.** Голдоо том, тойроод жижиг чулуун дараас бүхий дугуй булш. Хэмжээ: 3,1 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 27,0"  
E 100<sup>0</sup> 35' 31,0" elev-1232 м

**OR-203.** Голдоо чулуугүй том том чулуун дараастай дугуй булш. Хэмжээ: 4,4 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 26,3"  
E 100<sup>0</sup> 35' 30,9" elev-1229 м

**OR-204.** Голдоо чулуугүй жижгэвтэр чулуун дараас бүхий дугуй булш. Хэмжээ: 4,1 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 26,0"  
E 100<sup>0</sup> 35' 30,5" elev-1232 м

**OR-205.** Голдоо чулуу багатай, том том чулуун дараастай дугуй булш. Хэмжээ: 2,7 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 24,1"  
E 100<sup>0</sup> 35' 27,0" elev-1234 м

**OR-206.** Том том чулуун дараас бүхий дугуй булш. Хэмжээ:

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 24,3"  
E 100<sup>0</sup> 35' 26,2" elev-1235 м

**OR-207.** Голдоо чулуугүй том том чулуун дараас бүхий дугуй булш. Хэмжээ: 3,3 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 24,1"  
E 100<sup>0</sup> 35' 27,0" elev-1234 м



**OR-208.** Дөрвөлжин хүрээтэй, хүрээнийхээ 4 өнцөгт жижиг байгууламжтай. Голын байгууламж нь жижгэвтэр чулуун дараастай. Голын байгууламжийн хэмжээ: 9,5 м. Хүрээний хэмжээ: 26,2 x 22,9 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 25,5"  
E 100<sup>0</sup> 35' 26,0" elev-1234 м

**OR-209.** Дөрвөлжин хүрээтэй, хүрээний 4 өнцөгт том том чулуу босгожээ. Голын байгууламж нь хүрээтэйгээ нийлсэн байх ба голдоо чулуун овоолготой ажээ. Хэмжээ: 5,6 x 4,1 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 25,4"  
E 100<sup>0</sup> 35' 24,4" elev-1235 м

**OR-210.** Том том чулуун дараастай жижиг дугуй булш. Хэмжээ: 2,8 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 22,1"  
E 100<sup>0</sup> 35' 24,5" elev-1238 м

\* Дээрх байгууламжийн хойд талд 1 жижгэвтэр булш оршино. Хэмжээ: 2,5 м.

**OR-212.** Том том чулуун дараас бүхий жижиг дугуй булш. Хэмжээ: 1,8 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 21,7"  
E 100<sup>0</sup> 35' 24,2" elev-1241 м

**OR-213.** Том том чулуун дараас бүхий зууван дугуй хэлбэртэй байгууламж. Хэмжээ: 4,7 x 3,9 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 21,3"  
E 100<sup>0</sup> 35' 23,6" elev-1241 м

**OR-214.** Дараас чулууг нь ховхлон гадагш шидэлсэнээс хэлбэр нь алдагджээ.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 20,2"  
E 100<sup>0</sup> 35' 23,9" elev-1242 м

**OR-215.** Жижгэвтэр чулуун дараастай дугуй булш. Хэмжээ: 4 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 20,2"  
E 100<sup>0</sup> 35' 23,2" elev-1244 м

**OR-216.** Энд 2 зэрэгцээ байгууламж буй. Уг хоёр байгууламжийн дунд 1 дагуул бий.

а). Жижгэвтэр чулуун дараас бүхий дугуй байгууламж. Хэмжээ: 7,9 м.

б). Мөн жижиг дараас чулуутай дугуй байгууламж. Хэмжээ: 6,7 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 25,8"  
E 100<sup>0</sup> 35' 20,6" elev-1235 м

**OR-217.** Дөрвөлжин хүрээтэй, хүрээнийхээ 4 өнцөгт жижиг байгууламжтай. Хүрээний гадна зүүн талдаа 2 дагуултай, мөн зүүн талын хүрээг дайрсан 1 дагуул бүхий. Голын байгууламж нь жижгэвтэр чулуун дараастай. Голын байгууламжийн хэмжээ: 7,9 м. Хүрээний хэмжээ: 21 x 19 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 27,4"  
E 100<sup>0</sup> 35' 18,7" elev-1236 м

**OR-218.** Дөрвөлжин хүрээтэй, хүрээнийхээ 4 өнцөгт жижиг байгууламжтай, хүрээний гадна баруун талдаа 1 дагуултай. Голын байгууламж нь том том чулуун дараас бүхий. Голын байгууламжийн хэмжээ: 4,5 м. Хүрээний хэмжээ: 7,9 x 6,5 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 26,5"  
E 100<sup>0</sup> 35' 18,1" elev-1238 м

**OR-219.** Дөрвөлжин хүрээтэй, хүрээний нь 4 өнцөгт том том чулуу босгожээ. Голын байгууламж нь хүрээтэйгээ нийлсэн байдалтай. Хэмжээ: 5,4 х 5,35 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 26,6"  
E 100<sup>0</sup> 35' 17,3" elev-1239 м

**OR-220.** Дөрвөлжин хүрээтэй, хүрээний нь 4 өнцөгт том том чулуу босгожээ. Голын байгууламж нь хүрээтэйгээ нийлсэн байдалтай. Хэмжээ: 5,7 х 4,8 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 26,8"  
E 100<sup>0</sup> 35' 16,7" elev-1237 м

**OR-221.** Энэхүү дөрвөлжин булшны хойд талын хананаас бусад нь эвдэж сүйтгэн хэмжих боломжгүй болгожээ.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 27,4"  
E 100<sup>0</sup> 35' 14,4" elev-1237 м

**OR-222.** Дөрвөлжин хүрээтэй, хүрээний нь 4 өнцөгт том том чулуу босгожээ. Хүрээний нь баруун тал нь жалга руу нуржээ. Голын байгууламж нь жижиг чулуун дараастай, хүрээтэйгээ нийлсэн байх ажээ. Хэмжээ: 11,2 х 8,6 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 27,8"  
E 100<sup>0</sup> 35' 13,9" elev-1237 м

**OR-223.** Энэхүү булш нь зүүн талдаа буй жалга руугаа нурж хэмжээ авах боломжгүй болжээ.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 28,6"  
E 100<sup>0</sup> 35' 11,5" elev-1236 м

**OR-224.** Жижиг чулуун дараастай, дугуй хэлбэртэй байгууламж. Хэмжээ: 3,6 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 28,8"  
E 100<sup>0</sup> 35' 09,8" elev-1237 м

**OR-225.** . Жижиг чулуун дараастай, дугуй хэлбэртэй байгууламж. Хэмжээ: 4,9 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 29,1"  
E 100<sup>0</sup> 35' 08,9" elev-1237 м

**OR-226.** Жижгэвтэр чулуун дараастай дөрвөлжин хэлбэртэй булш. Хэмжээ: 4х 3,3 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 29,7"  
E 100<sup>0</sup> 35' 07,4" elev-1239 м

**OR-227.** Жижгэвтэр чулуун дараас бүхий энэхүү байгууламж нь баруун тал руугаа нурж хэмжээ авах боломжгүй болжээ.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 30,0"  
E 100<sup>0</sup> 35' 06,6" elev-1240 м

**OR-228.** Дөрвөлжин хүрээтэй, хүрээний нь 4 өнцөгт том том чулуу босгожээ. Хүрээний гадна урд талдаа 1 дагуултай. Голын байгууламж нь жижгэвтэр чулуун дараастай. Голын байгууламжийн 7,8 м. Хүрээний хэмжээ: 16,8 х 14,4 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 32,8"  
E 100<sup>0</sup> 35' 09,6" elev-1234 м

**OR-229.** Том том чулуун дараастай дөрвөлжин хэлбэртэй булш. Хэмжээ: 4,4 х 3,1 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 33,2"  
E 100<sup>0</sup> 35' 08,1" elev-1234 м

**OR-230.** Дөрвөлжин хүрээтэй, хүрээний нь 4 өнцөгт том том чулуу босгожээ. Голын байгууламж нь том том чулуун дараастай, зүүн болон баруун талаараа хүрээтэйгээ нийлжээ. Голын байгууламжийн хэмжээ: 6,7 м. Хүрээний хэмжээ: 8 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 20,1"  
E 100<sup>0</sup> 35' 10,9" elev-1241 м

**OR-231.** Том том чулуун дараас бүхий дугуй булш. Энэхүү булшны голын чулууг ховхолж авсан байх ажээ. Хэмжээ: 5,2 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 19,8"  
E 100<sup>0</sup> 35' 17,1" elev-1243 м

**OR-232.** Том том чулуун дараастай дугуй булш. Хэмжээ: 4,2 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 19,8"  
E 100<sup>0</sup> 35' 19,1" elev-1242 м

**OR-233.** Дөрвөлжин хүрээтэй, хүрээнийхээ 4 өнцөгт жижиг байгууламжтай. Хүрээний гадна баруун хойноосоо зүүн урд тал хүртлээ цуварсан 11 дагуул бүхий. Голын байгууламж нь том том чулуун дараастай. Голын байгууламжийн хэмжээ: 10,5 м. Хүрээний хэмжээ: 22 x 16,1 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 12,4"  
E 100<sup>0</sup> 35' 23,5" elev-1251 м

**OR-234.** Жижгэвтэр чулуун дараастай дугуй хэлбэртэй байгууламж. Хэмжээ: 6,7 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 12,4"  
E 100<sup>0</sup> 35' 23,5" elev-1249 м

**OR-235.** Голдоо чулуугүй, жижгэвтэр чулуун дараастай дугуй хэлбэртэй байгууламж. Хойд талдаа 1 дагуултай. Хэмжээ: 6,5 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 14,5"  
E 100<sup>0</sup> 35' 15,5" elev-1248 м

**OR-236.** Дөрвөлжин хүрээтэй, голын байгууламж нь том том чулуун дараастай бөгөөд урд талдаа 17 x 7,8 м хэмжээ бүхий үүдэвчтэй. Голын байгууламжийн хэмжээ: 14,6 м. Хүрээний хэмжээ: 19 x 18 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 13,0"  
E 100<sup>0</sup> 35' 15,5" elev-1251 м

**OR-237.** Голдоо хотгор, том том чулуун дараастай дугуй байгууламж. Зүүн талаас нь дараас чулууг ховхолж авсан байх ажээ. Хэмжээ: 7,9 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 13,5"  
E 100<sup>0</sup> 35' 09,0" elev-1254 м

**OR-238.** Дөрвөлжин хүрээтэй, хүрээний урд тал нь мэдэгдэхээ больж, зүүн талын хагас нь үлджээ. Голын байгууламж нь том том чулуун дараастай. Голын байгууламжийн хэмжээ: 8,1 м. Хүрээний хэмжээ: 12,3 x 10,6 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 09,5"  
E 100<sup>0</sup> 35' 13,1" elev-1256 м

**OR-239.** Голдоо том том чулуун дараастай, 4 өнцөгт нь том том чулуу босгосон дөрвөлжин булш. Хэмжээ: 5,5 x 2,5 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 08,1"  
E 100<sup>0</sup> 35' 05,5" elev-1261 м

**OR-240.** Том том чулуун дараас бүхий дугуй байгууламж. Хэмжээ: 5,9 м. Уг байгууламжийн баруун хойд талд том ургаа чулуу буй.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 07,0"  
E 100<sup>0</sup> 35' 08,8" elev-1263 м

**OR-241.** Дөрвөлжин хүрээтэй, зүүн урд өнцөг нь мэдэгдэхээ больжээ. Хүрээний гадна зүүн талдаа 2 дагуултай. Голын байгууламж нь том том чулуун дараас бүхий. Голын байгууламжийн хэмжээ: 8,8 м. Хүрээний хэмжээ: 11,7 х 10,7 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 05,0"  
E 100<sup>0</sup> 35' 09,3" elev-1261 м

**OR-242.** Голдоо хотгор том том чулуун дараас бүхий дугуй байгууламж. Хэмжээ: 7,15 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 03,6"  
E 100<sup>0</sup> 35' 06,9" elev-1264 м

**OR-243.** Энэхүү булш нь баруун талын жалга руугаа нурсанаас хэмжээг нь авах аргагүй болжээ.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 02,6"  
E 100<sup>0</sup> 35' 14,2" elev-1263 м

**OR-244.** Энэхүү байгууламжийн гадна хүрээ нь ихэд эвдэрч мэдэгдэхээ больсон байх ба голын чулуунуудыг нь ховхлон авсан байна. Хэмжээ: 9,5 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 59,7"  
E 100<sup>0</sup> 35' 10,7" elev-1264 м

**OR-245.** Дөрвөлжин хүрээтэй бөгөөд хүрээ чулууг ховхлон авсан байна. Голын байгууламж нь том том чулуун дараастай. Голын байгууламжийн хэмжээ: 9 м. Хүрээний хэмжээ: 11 х 9,5 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 57,2"  
E 100<sup>0</sup> 35' 08,9" elev-1274 м

**OR-246.** Дугуй хүрээтэй, хүрээ чулууг нь ховхлон авсан ор үлджээ. Голын байгууламж нь голдоо хотгор, том том чулуун дараас бүхий. Голын байгууламжийн хэмжээ: 11,2 м. Хүрээний хэмжээ: 15,2 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 55,1"  
E 100<sup>0</sup> 35' 07,9" elev-1279 м

**OR-247.** Дөрвөлжин хүрээтэй, хүрээний өнцгийн чулуунуудыг ховхолж авсан байна. Голын байгууламж нь том том чулуун дараастай бөгөөд хүрээтэйгээ нийлжээ. Хэмжээ: 10,3 х 7,6 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 53,4"  
E 100<sup>0</sup> 35' 06,1" elev-1282 м

**OR-248.** Том том чулуун дараас бүхий дугуй хэлбэртэй байгууламж. Хэмжээ: 7,6 м.

Байршил: GPS N 45<sup>0</sup> 02' 59,7"  
E 100<sup>0</sup> 35' 05,9" elev-1269 м

## Малтлага судалгаа

**Зэрэглээн бэлийн 1-р булш.** Их Богд уулын Битүүгийн амны зүүн хойд биед атираатсан шар толгодыг Зэргэлээн бэл гэх ба энэ бэлийн хойд талаар том хуурай сайр байна. Сайрын урд эрэгт хоорондоо 100 м зайтай хоёр булш байгаагийн баруун талын булшийг 1-р булш гэж нэрлэн малтлага хийсэн юм. Энэ булш нь хойд өргөрөгийн  $45^{\circ} 03' 47.0''$ , зүүн уртрагийн  $100^{\circ} 27' 35.2''$  солбилцолд орших ба дугуй дараастай, баруун хэсгээрээ голын усны хаялгын нөлөөгөөр жижиг чулуугаар нилээд хучигдсан байх ба хэмжээ нь хөндлөн огтлолоороо 7,5 м байна. Булшийг цэвэрлэсний дараах байдлыг ажиглахад дараасны захаар том чулуунуудыг өрж хашсан ба голдоо жижиг болон дунд зэргийн чулуугаар даржээ. Булшны анхны хэмжээ нь 6,9 м байсан байсан бололтой. Хашсан хүрээ чулуутай давхцуулан дөрвөн буланд дөрөв, дөрвөөр нь гонзгойдуу чулууг нийлүүлэн босгож, суурилуулан тавьсан ба баруун урд талынхаас бусад нь сайн мэдэгдэхгүй болжээ. Голын дараас чулууны зузаан нь төв хэсэгтээ 6 м, захаараа 3 м орчим байна. Улмаар дараас чулууг авч цэвэрлэхэд  $2,2 \times 1,1$  м хэмжээтэй оршуулгын нүхний ором илэрсэн ба зууван хавтгай хэлбэрийн хэд хэдэн том чулуугаар хөндлөн дарсан байна. Эдгээр дараас чулууны хажуугаар хүний хурууны зарим нэг яс болон мэрэгчийн яс ихээр гарч байна. Дараасыг авч доош 15 см-ийн гүн болтол малтахад хөлийн шилбэний яс, гавлын ясны оройн хэсэг, дунд чөмөгний ясны хугархайн хэсэг гарав. Ямар нэгэн эд өлгийн зүйл илэрсэнгүй. Зарим ясны үлдэгдлүүд олдож байгаа байдлыг ажиглахад хүнээ баруун хойш хандуулан тавьжээ. Малтлагыг үргэлжлүүлэхэд оршуулгын нүхний шаланд тулсан тул малтлагыг зогсоон нөхөн сэргээлт хийж булаав.

**Зэрэглээн бэлийн 2-р булш.** 1-р булшнаас зүүн тийш 100 орчим м зайд энэхүү булш орших бөгөөд хойд өргөрөгийн  $45^{\circ} 03' 48.3''$ , зүүн уртрагийн  $100^{\circ} 27' 36.5''$  солбилцолд далайн түвшинээс дээш 1385 м-ийн өндөрт байрлана.

Уг булш нь дугуй хэлбэртэй, голдоо чулуугүй, голын чулуугүй хэсгийг тойроод том том чулуун түүнийг тойроод жижгэвтэр чулуун дараастай байх ажээ. Хэмжээ: 6,8 м. Дараас чулууг авсаны дараа ямар нэгэн оршуулгын зан үйл үйлдсэн байдал мэдэгдэхгүй байсан бөгөөд улмаар булшны голд  $1,5 \times 2$  м-ийн хэмжээтэйгээр доош 30 см-ийн гүнд хүртэл малтлагыг үргэлжлүүлсэн боловч байгалийн эх хөрсөөрөө байсан тул малтлагыг зогсоон нөхөн сэргээлт хийж булаав.

**Цагаан өвдгийн 1-р булш.** Зэрэглээн бэлээс баруун хойш 3,5 км зайд цагаан чулуутай томоохон мөрөгцөгийн зүүн талаар нилээд хэдэн тооны хиргисүүр, булш байх ба эдгээрийн голд айлын өвөлжөөний урд талд малын хашаатай залган 1 дөрвөлжин булш оршино. Энэхүү булшийг 1-р булш хэмээн дугаарлав.

Том том хавтгай зууван мөлгөр чулууг босгон хашлага хийсэн ба дөрвөн өнцөгт нь том гонзгой чулуу босгосон байх ба баруун зүгт чиглэсэн байна. Зүүн талдаа хашлаганы гадна талд чулууг хавтгайгаар  $2,5 \times 5,4$  м хэмжээтэй талбайд дэвсэж, зэрэгцүүлэн өрж тавьсан байна. Уг булшны хашлага нь  $3,8 \times 5$  м хэмжээтэй ба гаднах байгууламжийн хамт нийт  $7,5 \times 5,4$  м хэмжээтэй.

Газар зүйн байршил нь хойд өргөрөгийн  $45^{\circ} 03' 03.4''$ , зүүн уртрагийн  $100^{\circ} 24' 08.5''$  солбилцолд байрлана. Хашлаганы дотор талыг цэвэрлэх явцад неолитын хасын төрлийн чулуугаар хийсэн дугуй хусуур 1 ш гол хэсгээс гарсан. 1-р үеийн дараас чулууг цэвэрлэсний дараах байдлыг ажиглахад 2 дахь үеийн дараасыг том том чулуугаар хийсэн болох нь мэдэгдэж байна. Малтлагыг үргэлжлүүлэхэд булшны зүүн хойд талаас галын ором, малын шатсан яс, урд талын хашлаганы дотор талд улаан шаргал өнгийн вааран эдлэлийн амсарын болон том жижиг хагархай хэсгүүд гарав. Цааш үргэлжлүүлэн малтлахад гурван том хавтгай, дугуй чулуун дараас илэрсэн бөгөөд 1-р буюу толгой талын чулууны хэмжээ  $1 \times 0,8$  м, зузаан нь 36 см, 2-р буюу дунд талын чулууны хэмжээ  $1,2 \times 0,9$  м, зузаан нь 34 см, 3-р буюу хөл талын чулууг хажуугаар нь босгож тавьсан байх ба хэмжээ  $1,36 \times 0,97$  м, зузаан нь 35 см.

Эдгээр 3 чулууны нэг тал нь хотгор, эсрэг тал нь гүдгэр байна. Мөн 1-р чулууны дээрээс дахин 1 ш дугуй хусуур гарсан бол анхны хусуур гарсан хэсгийн доод талаас 2-р дараас байгаа нь 1, 2-р дараас чулууны дээд талд хусууруудыг тавьжээ. Дараас чулуунуудыг авахад 2-р дараас чулуун доороос дээрээс олдож байсан ваарны хагархайтай адил хэсгүүд гарав. Малтлагыг цааш үргэлжлүүлэн 56 см-ын гүн болж ирэхэд ямар нэг зүйл илрээгүй бөгөөд булшны нүх нь доод талдаа 1,4 x 0,55 м болж хадархаг хөрс болж өөрчлөгдсөн учир малтлагыг зогсоон, зүүн талын хашлаганы гадна талын хэсгийг цэвэрлэж үзэхэд мөн дээрх ваарны хагархайн ижил хагархай 3 ш, неолитын үеийн шаантган үлдэц 1 ш олдсон нь магадгүй уг булшийг тонохдоо дотроос гаргасан шороотой хамт гадагш гарсан байж болох бүрэн боломжтой юм. Энэхүү булшийг тонохдоо хөлийн хэсгийн дараас чулууг хөндөж хашлаганы урд хэсгээс нэгийг нь гадагш унаган тэр хэсгээр орж тоносон болохыг вааран эдлэлийн олдож байгаа газраар тодорхойлж болохоор байна. Эндээс неолитын үеийн чулуун зэвсэг 3 ш гарсанаас шаантган үлдэц 1 ш, дугуй буюу хумсан хусуур 2 ш, шороон саарал өнгийн ваар савны амсарын хагархай 7 ш, бусад хэсгийн хагархай 6 ш, хар саарал өнгийн маш сайн шатаалттай ваарны хагархай 1 ш гарсан бөгөөд малтлагыг үргэлжлүүлэхэд байгалийн эх хөрсөндөө хүрсэн тул зогсоож нөхөн сэргээлт хийж булав.

Булшнаас гарсан олдворуудын тодорхойлолт:

1. Шаантган үлдэц-1ш. Хар саарал өнгийн цахиураар хийсэн шаантган үлдэцний нүүрэн талаас, хажуугийн нэг талаас хэд хэдэн цуулалтаар ялтас цуулан авсан байна. Уг үлдэцийг бэлтгэхдээ цохилтын талбайг нэг хөндлөн цуулалтаар цуулан бэлтгэсэн байна. Хэмжээ нь: 12 x 18 x 38мм
2. Дугуй хэлбэрийн хусуур 2ш. 15 x 16 x 3мм хэмжээтэй хар саарал өнгийн цахиурын төрлийн чулуунаас авсан залтасыг холтчих аргаар ирлэн хусуур зэвсэг болгожээ. 16 x 19 x 6мм хэмжээтэй цайвар улаан өнгийн цахиураар хийсэн залтсыг ашиглан давхар ир оруулан хусуур хийсэн байна.
3. Вааран эдлэлийн амсарын хагархай 7ш. Шороон саарал өнгийн вааран савны амсарын хагархай олдсон ба эдгээрийг эвлүүлэн үзвэл уг эдлэл нь вааран тогоо бололтой байна. Амсарын хээг гаргахдаа хэрчилээстэй эдлэлээр дотор, гадна талд нь дарах аргаар хээ гаргажээ. Амсраас доош дундажаар 58мм зайд товгор гөрмөл хээтэй байгаа нь уг хээ нь гоёл чимэглэлээс гадна бариулын зориулалтаар ашиглах боломжтой юм. Энэ вааран эдлэлийн амсарын хөндлөн огтлол нь ойролцоогоор 230мм хэмжээтэй.

**Цагаан өвдгийн 2-р булш.** Энэхүү булш нь 1-р булшнаас баруун тийш м орчим зайд хойд өргөрөгийн  $45^{\circ} 03' 03,1''$ , зүүн уртрагийн  $100^{\circ} 24' 06,7''$  солиболцолд далайн түвшинээс дээш 1385 м-т оршино.

Уг булш нь жижгэвтэр, дугуй хэлбэртэй, дунд зэргийн чулуун дараастай ба дараас чулуунууд хөдөлсөн байдалтай. Хэмжээ: 2,6 м. Дараас чулууг авахад хүний оршуулга илрэв. Хүнээ байгалийн эх хөрсөн дээр баруун урагш хандуулан тавьсан байх ба ихэд сүйтгэгдсэнээс анхны тавилтаасаа өөрчлөгджээ. Нас барагчийн нүүрийг урагш харуулсан байх бөгөөд цээжин хэсэгт нь 2 дунд чөмөгний яс, 2 шилбэний яс, бугалга, шуу, далны яс, хавирганы ясны хугархайнуудыг бөөгнүүлэн орхижээ. Хүний яснуудыг авсаны дараа малтлагыг үргэлжлүүлэхэд ямар нэгэн эд өлгийн зүйл илрээгүй бөгөөд байгалийн эх хөрсөндөө тулсан учир зогсоож нөхөн сэргээлт хийж булав.

**Цагаан өвдгийн 3-р булш.** Энэхүү булш нь 2-р булшны зүүн хойд талд 3 м орчим зайд хойд өргөрөгийн  $45^{\circ} 03' 03,2''$ , зүүн уртрагийн  $100^{\circ} 24' 06,7''$  солбилцолд далайн түвшинээс дээш 1621 м-ийн өндөрт оршино.

Уг булш нь дугуй хэлбэртэй бөгөөд дунд зэргийн чулуун дараастай. Хэмжээ: 1,8 м. Дараас чулууг авахад ямар нэгэн оршуулгын зан үйл үйлдсэн байдал илрээгүй бөгөөд эх газрын хөрсөндөө тулсан учир малтлагыг зогсоон нөхөн сэргээлт хийж булав.

**Цагаан өвдгийн 4-р булш.** Энэхүү булш нь 3-р булшнаас зүүн тийш 5 м орчимд хойд өргөрөгийн  $45^{\circ} 03' 03,2''$ , зүүн уртрагийн  $100^{\circ} 24' 07,2''$  солбилцолд далайн түвшинээс дээш 1620 м-ийн өндөрт оршино.

Уг булш нь дугуй хэлбэртэй бөгөөд дунд зэргийн чулуун дараастай. Хэмжээ: 3,6 м. Дараас чулууг авахад ямар нэгэн оршуулгын зан үйл үйлдсэн байдал илрээгүй бөгөөд байгалийн эх хөрсөндөө тулсан учир малтлагыг зогсоон нөхөн сэргээлт хийж булав.

**Цагаан өвдгийн 5-р булш.** Энэ булш нь 1-р булшнаас зүүн урагш 100 м зайд гадуураа хүрээгүй дунд зэргийн хиргисүүрийн чанх баруун талд 10 м зайтай оршино. Газарзүйн байршлын хувьд хойд өргөрөгийн  $45^{\circ} 03' 02,3''$ , зүүн уртрагийн  $100^{\circ} 24' 10,2''$  солбилцолд далайн түвшинээс дээш 1611 м-ийн өндөрт оршино. Булшны гадаад зохион байгуулалт нь дугуй хэлбэрийн анхны байдлаар хөндлөн огтлол нь 410 см, дунд зэргийн дараас чулуутай, дараасны захаар нь том том чулуугаар хашжээ. Цэвэрлэсний дараах байдлаар булшны хөндлөн огтлолын хэмжээ нь 3, 5 м болж байна. Бүх дараасыг цэвэрлэж 15 см гүн малтахад байгалийн хөрс нь илэрч, ямар нэг оршуулгын зан үйл үйлдэгдсэн гэх шинж илрээгүй тул малтлагыг зогсоон нөхөн сэргээлт хийж булав.

**Цагаан өвдгийн 6-р булш.** Энэхүү булш нь 1-р булшнаас зүүн хойш 20 орчим м зайд хойд өргөрөгийн  $45^{\circ} 03' 05,2''$ , зүүн уртрагийн  $100^{\circ} 24' 15,3''$  солбилцолд далайн түвшинээс дээш 1598 м-ийн өндөрт оршино.

Уг булш нь дугуй хэлбэртэй, том том чулуун дараастай. Хэмжээ: 4, 2 м. Дараас чулууг авсаны дараа ямар нэгэн оршуулгын нүхний ором илрээгүй боловч хүний гавлынх байж болохоор хавтгай ясны үлдэгдэл газрын өнгөн хөрсөн дээрээс олдсон бөгөөд өөр яс болоод эд өлгийн зүйл гарсангүй.

**Тарималтын 1-р булш.** Энэ булш нь Зэрэглээн бэлийн 1-р булшнаас баруун зүгт 800 м зайд хуучин эвдэрсэн усан сангийн дэргэд зэрэгцээ хоёр булш байгаагийн баруун хойд талынх нь юм. Газар зүйн байршил хойд өргөрөгийн  $45^{\circ} 03' 32,9''$ , зүүн уртрагийн  $100^{\circ} 26' 38,7''$  солбилцолд далайн түвшинээс дээш 1431 м-ийн өндөрт оршино. 1-р булш нь 6,6 см хэмжээтэй ба дараас чулуун нь бараг мэдэгдэхгүй захаараа тойрсон цөөхөн чулуутай, голдоо чулуун дараасгүй байна. Бид өнгөн хөрсийг цэвэрлэж, 30 см гүн малтахад оршуулгын нүхний ором илрээгүй тул цааш үргэлжлүүлэн 10 см гүн малтахад булшны 2-р дараас чулуу гарч ирсэн юм. 2-р дараас чулууг цэвэрлэж цааш 2,6 x 1,4 м хэмжээтэй 1,2 м гүн малтахад бог малын яс гарсан. Бид цааш малтахдаа нүхний хэмжээгээ өргөсгөн 3,3 x 2,7 м хэмжээтэй болгон малтаж 1,4 м гүн болоход гол хэсгээс хүний эрүүний яс гарсан ба нэг тал нь бараг мэдэгдэхгүй болжээ. 1,62 м малтахад булшны нүхний амсар мэдэгдсэн ба нүхний хойд хэсгээс нь авсны модны зарим хэсэг, дунд хэсгээс хүний гавлын яс /дээд хэсэг нь л үлдсэн/, дунд чөмөгний яснууд нь босоо байрлалтай гавлын ясны доод талд далны яс байгаа ба зарим аль хэсгийн ясны болох нь мэдэгдэхгүй үйрмэг яс хаа сайгүй гарч байгаа нь мэрэгчийн нүх нилээд хэд байгаатай холбоотой юм. 1,7 м гүн малтахад авсны дээд талын хэсэг үл мэдэг мэдэгдэж байгаа ба тонох явцад ихэд эвдэрчээ. Дээрх яснуудыг авч цааш малтахад гавлын яс байсан хэсэг буюу авсны дунд хэсгээс ясаар хийсэн нумны гичир 1 ш, модон том чагт 1 ш, жижиг чагт 1 ш гарлаа. Авсны дотор талаар малтлагыг үргэлжлүүлэхэд хөл талаараа бага зэрэг хөндөгдсөн байв Авсны доод хэсэгт баруун хөлийн хажуу талаас дугуй хэлбэрийн хүрэл зүүлтэн чимэглэл 6 ш, хүрэл арал 1 ш, төмөр зэв 1 ш олдсон. Төмөр зэвийг хөлрүү чиглүүлэн тавьжээ. Авсны шаланд

нарийн савхан урт модыг дэвсэж дээр нь хүнээ оршуулсан байна. Уг шаланд дэвссэн савх моднуудын дунд үзүүртэй төмөр эдлэл байсан бололтой 1.5 см голчтой, 20.5 см урттай модны хугархай байна. Эндээс ямар зориулалттай болох нь мэдэгдэхгүй төмөр эдлэлийн хэлтэрхийнүүд олон тоотой олдсон ба хэлбэрийн хувьд конус хэлбэртэй, хагас дугуй хэлбэртэй, хавтгай хэлбэртэй байхаас гадна зарим төмөр нь модонд суулгаж байсны ул мөртэй байна. Энэ булшны авсны хэмжээ нь мэдэгдэж байгаа байдлаараа 1,8 м урттай, толгой талаараа 76 см, хөл талаараа 46 см өргөнтэй, 50 см өндөртэй байх ба дөрвөн буланг нь углуурга гаргасан нь эндээс гарсан авсны модны үлдэгдлээс мэдэж болохоор байна. Авсны гадна талаар малтаж үзэхэд зүүн дээд талаас хайрган шороон дотроос их сайн хадгалагдсан хөл хэсгээс олдож байсан эдлэлтэй адил 1 ш, өөр нэг хүрэл эдлэл 1 ш олдсон. Мөн толгой талаас байрлал болон ямар бог малын яс нилээд гарав. Энэ булш нь нилээд их тоногдсон байх ба хүнийг толгой талаас нь татаж дээш нь харуулсан ингэхэд шилбэний яс хэвээр үлдсэн нь оршуулсанаас хойш нилээд хожуу тоножээ. Малтлагыг үргэлжлүүлэхэд байгалийн эх хөрсөндөө тулсан учир нөхөн сэргээлт хийж булав.

Булшнаас гарсан олдворуудын тодорхойлолт:

1. Нумын гичир 1 ш. 140 мм урттай ба ясаар хийсэн хадгалалт сайн.
2. Модон чагт 2 ш. Том нь 12 мм урт, хоорондоо 25 мм зайтай нүхэлсэн, гаргасан нүхний хэмжээ нь 11 мм х 4 мм. Хадгалалт маш муу гурван хэсэг хугарсан. Жижиг чагт нь 50 мм хэмжээтэй голдоо нэг нүхтэй.
3. Хүрэл товруу 7 ш. Бүсний чимэглэлийн зориулалттай. 30-32 мм хөндлөн огтлолтой, цутгаж хийсэн товруунуудын 1 нь хадгалалт дунд зэрэг сэнжний нүх нь 15 х 10 мм хэмжээтэй. 6 ш нь хадгалалт маш муу зэвэнд маш их идэгдсэн сэнж нь бүгд унасан.
4. Хүрэл арал 1 ш. Энэ арал нь нэг тал нь бүтүү, нөгөө тал нь чаги хэлбэртэй, хадгалалт маш муу, 31 мм х 26 мм хэмжээтэй.
5. Бүсний хүрэл чимэг 1 ш. Энэ нь суран бүсний үзүүрийн чимэгний зориулалттай 42 мм х 10 мм хэмжээтэй сэнж бүхий, хадгалалт дунд зэрэг.
6. Модон эдлэлийн хугархай 1 ш, үзүүртэй төмөр эдлэл байсан бололтой 1.5 см голчтой, 20.5 см урттай модон эдлэлийн хугархай.
7. Төмөр зэв. Хадгалалт муу, зөвхөн мөсөнд суулгасан хэсэг л үлдсэн байна.

**Тарималтын 2-р булш.** Энэхүү булш нь 1-р булшнаас зүүн хойш 500 орчим м зайд хойд өргөрөгийн  $45^{\circ} 03' 47.2''$ , зүүн уртрагийн  $100^{\circ} 27' 11.3''$  солбицолд далайн түвшинээс дээш 1413 м-ийн өндөрт оршино.

Уг булш нь голдоо чулуугүй, тойроод дунд зэргийн чулуун дараастай, зүүн урд тал руугаа дараас чулуу нь шигүү болж өндөрсөж иржээ. Хэмжээ: 6 м. Дараас чулууг аван 2 х 2 м-ийн хэмжээтэй талбайгаар малтлагыг үргэлжлүүлэн 20 см болоход зүүн хойш чиглэсэн  $30^{\circ}$ -ын хазайлттай чигжээс чулуу илэрсэн бөгөөд хөндсөн байдалтай сул байв. Чигжээс чулууг авсаны дараа оршуулгын нүхний ором мэдэгдэхгүй байсан тул доош үргэлжлүүлэн малтахад 190 см-ийн гүнээс хүний гарын хурууны яснууд малтлагын нүхний хойд ханан талаас илрэв. Улмаар доош 20 см-ийн гүнтэйгээр малтлагыг үргэлжлүүлэхэд авсны таг илэрсэн бөгөөд хөл талын таг мод нь байхгүй, толгойн талын таг модны үлдэгдэл нь босоо байдалтай байв. Малтлагыг үргэлжлүүлэн 240 см-ийн гүн болж ирэхэд авсны шал гарч ирсэн бөгөөд түүний дээгүүр нарийн савхан мод уртааш нь зулж тавиад дээр нь нас барагчийг тавьсан бололтой. Авсны гадна хойд талаар хүний дунд чөмөг, хурууны болон шууны яснууд, мөн 3 онгит сумны зэв 2 ш, хэдэн хэсэг хугарсан төмөр хутга, авсны төмөр бүслүүр, юу нь үл мэдэгдэх төмөр эдлэлийн үлдэгдлүүд, нум сумны хоромсогоны хэсэг гарч байгаа нь энэ булшийг тоногдсон болохыг харуулж байна. Авсны урд талаар малтлагыг үргэлжлүүлэхэд морины яс илрэв. Уг морийг эмээл хазаартай оршуулсан байх ба зүүн хойш чиглүүлэн дээш харуулж, толгойг нь урд зүг хандуулан дөрвөн хөлийг нь нугалж тавьсан байдалтай бөгөөд хөндөгдөөгүй бүтнээрээ байв. Эмээлийн мод нь өмхөрч муудан авах боломжгүй болсон, хоёр дөрөө нь цээжний ясны орчимд,



морины аманд нь амгай нь зуулттай, мөн толгойны орчимд хазаарын хүрэл арал болон хазаарын ясан зуузай, чимэглэлүүд олдов. Хүний гарын хурууны яснууд нь голдуу морины хөл талаас гарч байгаагаас үзэхэд хүнээ баруун урагш Их богд уулын зүг харуулан тавьсан бололтой. Олдворуудыг авч доош малтлагыг үргэлжлүүлэхэд байгалийг эх хөрсөндөө тулсан учир нөхөн сэргээлт хийж булсан болно.

Булшнаас гарсан олдворуудын тодорхойлолт:

1. Хазаарын чимэглэлүүд. а) 2 ш хазаарын ясан зуузай. Амьтны эврийн үзүүрт төмөр суулган хийсэн бололтой, үзүүрт нь төмрийн үлдэглэл байна. б) 2 ш хүрэл арал. Морины толгойн ар талаас нэг арал нь олдсон бөгөөд сурны үлдэгдэлтэй байгаа нь хазаарын арал болохыг илэрхийлж байна. Нөгөө арал нь хэмжээгээр арай бага бөгөөд хазаарын сагалдарганы арал бололтой. в) 2 ш хүрэл цагираг. Нэг нь бүтэн, нөгөө нь хугархай бөгөөд 1.3 х 2.1 см хэмжээтэй байна. г) 5 ш хүрэл чимэглэл. Хазаарын унжлага сурны үзүүрийн чимэглэл бололтой бөгөөд ард талдаа 2 хадаастай, хос хосоороо хэмжээ болоод хээгээрээ адилхан байх ажээ.
2. Сумны төмөр зэв 2 ш. Нэг зэв нь бараг танигдахгүй болжээ. Нөгөө зэв нь хэдийгээр зэвэнд идэгдсэн боловч 3 онгитой болох нь мэдэгдэхүйц байна.
3. Төмөр хутганы хугархай. Гадна талаараа модны үлдэцтэй, олон хэсэг хугарсан төмөр хутга, ойролцоогоор 30 гаруй см-ийн урттай, дунджаар 2 см-ийн өргөнтэй. Гадна талаараа модны үлдэцтэйгээс үзвэл модон хуйтай байсан бололтой.
4. Авсны төмөр бүслүүрийн үлдэгдэл. 2.3 см-ийн өргөнтэй нимгэн төмрийн 4, 5 ш хугархайнууд гарсан нь авсны бүслүүр байж болох юм.

## Дүгнэлт


Орог нуурын баруун хөвөөнөө орших 246 тооны булш, хиргисүүрүүд нь хэлбэр болоод хэмжээний хувьд харилцан адилгүй бөгөөд он цагийн хувьд ч гэсэн түүхийн олон үед хамаарч байна. Хиргисүүрийн байгууламжуудыг дөрвөлжин хүрээтэй, дугуй хүрээтэй, гадна хүрээгүй, булшны байгууламжуудыг гадна хэлбэрээр нь дөрвөлжин, дугуй хэлбэртэй (голдоо чулуугүй, голдоо чулуутай), хөндөгдөж хэлбэрээ алдсан хэмээн ангилж болох бөгөөд он цагийн хувьд хиргисүүрүүд нь хүрэл зэвсгийн үед, булшнууд нь хүрэл зэвсгийн болон Хүннү гүрний үе болоод эртний Түрэг улсын үед холбогдох боломжтой.

Үүнд: Дөрвөлжин хүрээтэй хиргисүүр 81, дугуй хүрээтэй хиргисүүр 20, гадна хүрээгүй хиргисүүр 70, дөрвөлжин булш 23, дугуй булш 52, хөндөгдөж хэлбэрээ алдсан булш 2 байна.

Мөн бидний малтлага судалгаа хийсэн Их богд уулын зүүн суганд орших Зэрэглээн бэл, Цагаан өвдөг, Тарималт зэрэг газруудад буй 10 орчим булшны хэрэглэгдэхүүнээс үзэхэд түүхийн өөр өөр үед холбогдох боломжтой байна. Зэрэглээн бэл 1-р булшны хүний оршуулгаас аль мөчний яс болох нь үл мэдэгдэх ясны үйрмэг хэлтэрхийнүүд олдож байгаа нь уг булшны оршуулгын зан үйлийг тодорхойлох боломж тун хомс байна. Цагаан өвдгийн 2-р булшны хүний оршуулга нь бага зэрэг хөндөгдсөн байсан ба гавлын болон бусад мөчний ясаар баримжаалан үзэхэд хүнээ хөрсөн дээр ямар нэг оршуулгын нүх ухалгүйгээр чулуугаар дарж, баруун урагш зүгт баруун хажуугаар нь хэвтүүлэн, хөл, гарыг агийлган нугалж тавьсан байна. Цагаан өвдгийн 1-р булшнаас хүний оршуулга гараагүй бөгөөд эндээс неолитын үед хамаарах шаантган үлдэц, хусуур зэвсэг нь Монгол болон бусад хөрш зэргэлдээ орнуудын хүрлийн үеийн зарим нэг дөрвөлжин булшнаас олддог байна. Мөн эндээс вааран эдлэлийн амсарын хагархай болон бусад хэсгийн хагархайнуудаас үзвэл уг ваарыг амсараараа 23 см хөндлөн огтлол бүхий вааран тогоо байсан гэж үзэж болохоор байна. Зэрэглээн бэлийн 2-р булш, Цагаан өвдөгийн 3, 4, 5-р булшнуудаас хүний оршуулга болон эд өлгийн зүйлс гараагүй бөгөөд



Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын нутаг Чандмана хар уулын булш, мөн Өмнөговь аймгийн Богд сумын нутаг Оюу-толгойн булшнуудтай гадна хэлбэрээрээ болон эд өлгийн зүйл огт байхгүй зэргээрээ адилсаж байгаа нь эдгээр булшнуудыг хүрэл зэвсгийн үед холбогдох боломжтойг илэрхийлж байна. Тарималтын хоёр булшнаас гарсан эд зүйл нь Архангай аймгийн Хутаг уулын Түрэг булш, Хана уулын Түрэг булш, мөн Хэнтий аймгийн Төгөс өвдгийн булш зэргээс гарсан морьтой оршуулганы морио тавьсан байдал болон морины хазаарын чимэглэл, бүсний хүрэл товруунууд, төмөр хутганы үлдэгдэл ижилсэж байгаа нь уг хоёр булшийг эртний Түрэг улсын үед холбогдох болохыг баталж байна. Ялангуяа 2-р булшнаас морьтой оршуулга гарсан нь шинжлэх ухааны хувьд сонирхолтой бөгөөд тухайн үеийн хүмүүсийн ахуй амьдрал, эд хэрэглэл, ертөнцийг үзэх үзэл хийгээд оршуулгын зан үйлийн онцлог зэргийг судлахад ихээхэн ач холбогдолтой юм.

Энд заавал дурьдах ёстой нэг зүйл бол дээрх газруудад байгаа булш, хиргисүүрүүдээс 10 гаруй нь тоносон явдал юм.



Зэрэглээн бэлийн 1-р булшны дэвсгэр зураг.

Fig. 1



Зэрэглээн бэлийн 1-р булшны хүрээ ба оршуулгын зохион байгуулалт

Fig. 2



Зэрэглээн бэл 1-р булш



Зэрэглээн бэл 1-р булш

Fig. 3 and 4



Зэрэглээн бэл 1-р булш




Зэрэглээн бэлийн 1-р булшны хүрээний зохион байгуулалт

Fig. 5 and 5 bis



Зэрэглээн бэлийн 1-р булшны оршуулгын зохион байгуулалт




Зэрэглээн бэлийн 2-р булшны дэвсгэр зураг

Fig. 6 and 7





Зэрэглээн бэлийн 2-р булш



Цагаан өвдагийн 1-р булшны дэвсгэр зураг

Fig. 8 and 9





Цагаан өвдөгийн 1-р булшны зураг  
/зүүн талаас/



Цагаан өвдөгийн 1-р булшны зураг  
/баруун талаас/

Fig. 10 and 11



Цагаан өвдөг 1-р булшны 2-р дараасны зураг




Цагаан өвдөг 1-р булшны 2-р дараасны зураг

Fig. 12 and 13



Цагаан өвдөгийн 1-р булшны малтлагын дараахь байдал



Цагаан өвдөгийн 1-р булшнаас гарсан шаантган үлдэц, хусуурууд


Fig. 14 and 15





Цагаан өвдөгийн 1-р булшнаас гарсан ваарны хэлтэрхийнүүд

Fig. 16




Цагаан өвдөгийн 2-р булшны дэвсгэр зураг А. Хүний шилбэний яс ил гарсан хэсэг




Цагаан өвдөгийн 2-р булш

Fig. 17 and 18



2-р булшны хүний оршуулгын гар ба фото зураг



Тарималтын 1-р булшны дэвсгэр зураг

Fig. 19 and 20



Тарималтын 1-р булш



Тарималтын 1-р булшны хүний эрүүний яс

Fig. 21 and 22






Тарималтын 1-р булшны хүний гавлын ясны хэсэг ба  
мөчдийн ясны хэсэг



Тарималтын 1-р булшны олдворын зураг

Fig. 23 and 24





1-р булшны олдворууд 1,2-модон чагт, 3-хүрэл арал, 4,5-бүсний хүрэл чимэг, 6-12 – бүсний хүрэл толь



Тарималтын 2-р булшны дэвсгэр зураг

Fig. 25 and 26



Тарималтын 2-р булш



Тарималтын 2-р булш

Fig. 27 and 28




Тарималтын 2-р булшны хүний оршуулга байсан хэсэг




Тарималтын 2-р булшны морины оршуулга

Fig. 29 and 30



Тарималтын 2-р булшны олдворууд 1- Төмөр сумны зэв, 2,3- хүрэл арал, 4,5, 6, 9, 10 –хүрэл унжлага, 7, 8- хүрэл цагираг чимэг, 11,12- ясан амгай

Fig. 31



Тарималтын 2-р булшнаас гарсан төмөр эдлэлийн хугархай 13-19,  
 21-23, 25-27- төмөр эдлэлийн хугархай, 20, 24- төмөр хутганы  
 хугархай

Fig. 32



Тарималтын 2-р булшны олдворуудын фото зургууд

Fig. 33